



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ


Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.7%, 2020 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +8.5%, 2020 онд: 7.5%

Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий -9.6%, 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +7.1%,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: -10.8%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА


Төсвийн тэнцэл 7-р сарын байдлаар 343.1 тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 77.5 хувиар, зарлага 83.37 хувиар тус тус буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 343.13 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 33.15 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 7 төгрөгөөр нэмэгдлээ.

Долоодугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 23.4 төгрөг буюу 8.1 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 7.08 төгрөг буюу 0.27 хувиар нэмэгдэж 2661.55 төгрөг болов. 7-р сард гадаад валютын нөөц 3.6 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 12 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар тус тус өсчээ.




Инфляцийн түвшин 7.7%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 7-р сарын байдлаар өмнөх сараас 0.2 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар, оны эхнээс 5.1 хувь өсөв. Өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өсөхөд хүнсний бараа, орон сууц, ус, цахилгаан, эм тарианы үнийн дүн нэмэгдсэн хэвээр байна.




Гадаад худалдааны тэнцэл 1064 сая.ам доллар болов.

2019 оны долоодугаар сард нийт барааны эргэлт 8079 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 11, импорт өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 1064 сая ам.долларын ашигтай гарлаа.



8-Р САРЫН ОНЦЛОХ: МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР

Эх сурвалж: www.1212.mn

2019 оны хоёрдугаар улирлын байдлаар Засгийн газрын нийт гадаад өр 7.2 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 29.6 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр (15.8 сая ам.доллар)-иар буурсан бол, Улсын нийт гадаад өр 1% (171 сая ам.доллар)-иар өссөн байна. Харин төв банкны өр 2% буюу 38.4 сая ам.доллараар буурсан бол хадгаламжийн байгууллагуудын өр 6% буюу 148 сая ам.доллараар тус тус буурчээ. Нийт гадаад өрийн 24%-ийг засгийн газрын өр, 7%-ийг Төв банкны өр, 8%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 29%-ийг бусад салбаруудын өр, 33%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

ФИТЧ АГЕНТЛАГ ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ХЭВЭЭР ҮЛДЭЭВ.

- Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийг "В", төлөвийг "Тогтвортой" хэвээр, богино хугацааны зээлжих зэрэглэлийг мөн "В" хэвээр хадгалсан байна. Тус агентлагаас "Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтворжиж, төсвийн болон засаглалын үзүүлэлтүүд сайжирч байна. Энэ нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд эерэгээр нөлөөлөв" гэсэн байна. Гэвч Монгол Улс эдийн засгийн хязгаарлагдмал суурьтай хэвээр, гадаад нөөцийн хамгаалалт (buffer) хангалтгүй, улс төрийн тогтворгүй байдал нь эдийн засгийн бодлогыг огцом өөрчлөх нөхцөл байдлыг үүсгэх эрсдэлтэй зэрэг үндэслэлээр зээлжих зэрэглэлийн үнэлгээг хэвээр үлдээжээ. Монгол улсын төсвийн ашиг 2018 онд ДНБ-ийн 2.6 хувьд хүрч, баталсан төсөв "Фитч" агентлагийн төсөөлсөн дүнгээс давсан байна. Орлогыг нэмэх шинэ зүйл хийж, хэрэгжүүлээгүй хэдий ч 2019 оны 5 дугаар сарын төслийн гүйцэтгэлийн мэдээгээр орлого болон зардал тогтвортой өссөн байна. Төсвийн гүйцэтгэл сайжирч, эдийн засгийн сэргэлт үргэлжилснээр Засгийн газрын нийт өр (GGGD) огцом буурч буй юм. "Фитч" агентлагийн суурь төсөөллөөр 2019 оны эцэст Засгийн газрын өр ба ДНБ-ий харьцаа 60 хувьд хүрч, 2020 оноос эхлэн алгуур буурах хандлагатай байна.

БИЗНЕС ИЛТГЭЛИЙН ИНДЕКС АНХ УДАА ЭЕРЭГ ГАРЧЭЭ.

Бизнесийн төлөөллийн байгууллага МҮХАҮТ-аас явуулдаг судалгаагаар 2018 оны бизнесийн итгэлийн ерөнхий индекс үзүүлэлт эерэг буюу 0.47 гарчээ. Дээрх индексийг 2017 онтой харьцуулахад 0.79 нэгжээр өссөн байна. Бизнес итгэлийн индекс эерэг утгатай байгааг эдийн засгийн өсөлт, ялангуяа томоохон төслүүдийн бүтээн байгуулалт өрнөж байгаатай холбон үзэж болно хэмээн МҮХАҮТ-ын мэдээнд дурдсан байна. Судалгаанд оролцсон нийт бизнес эрхлэгчдийн 54 хувь нь бизнесийн ерөнхий орчин өмнөх жилээс сайжирсан гэж дүгнэсэн бол 24 хувь нь макро эдийн засгийн орчин сайжирсан гэж үзжээ. 2018 онд бизнесийн орчны тулгамдсан асуудлаар эхний хоёр байранд "Зээлийн хүү өндөр, хугацаа богино", "Бодлогын тогтворгүй байдал" гэж нэрлэж байсан нь өмнөх жилийнхтэй ижил хэвээр байгаа юм. Бизнесийн орчныг үнэлэх зорилготой Бизнесийн итгэлийн индексийн судалгааг энэ жил 18 дах удаагаа явуулжээ. Судалгааны асуулгыг Улаанбаатар хот, орон нутгийн нийт 845 бизнес эрхлэгчдийн дунд ярилцлага ба онлайн хэлбэрээр 2019 оны 4-6 дугаар сард явуулсан байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 7-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 7-р сар 2019 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn